

Дэлхийн хүний хөгжлийн илтгэл, үүсэл хөгжил : 1990-2006

Б.Бат, МУИС-ийн ЭЗС-ийн багш, доктор (Ph.D)

Дэлхийн хүний хөгжлийн илтгэл нь 1990 оноос эхлэн НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд Пакистаны нэрт эдийн засагч Махбуб Улл Хакийн санаачилга, хүчин зүтгэлээр хэвлэгдсэн юм. Чухам энэ үеэс хүний хөгжлийн үзэл баримтлал дэлхий даяар тархах үндэс суурь тавигджээ. 1990-2006 оны илтгэлүүдэд тусгасан зүйлийг товчоор илэрхийлвэл:

1990 он- Эдийн засгийн өсөлт болон хүний хөгжил хоёрын хоорондын харилцан хамаарлыг анх судлан гаргаж, хөгжиж буй орнуудын хөгжлийн стратеги төлөвлөгөө нь дээрх чанаргүй өсөлтөөс зайлсхийж чанартай өсөлтийг бий болгоход чиглэгдэх ёстойг зөвлөмж болгосон байдаг.

1991 он- Хүний хөгжлийн асуудлуудыг санхүүжүүлэх механизмыг дэлгэрэнгүй авч үзжээ. Энэхүү илтгэлийн гол дүгнэлт нь төсвийн зарлагын бүтцийг өөрчилснөөр анхдагч нийгмийн үйлчилгээг санхүүжүүлэх хангалттай нөөц бололцоо байгааг гаргаж тавьсанд оршино.

1992 он- Зах зээлийн боломжийг хүртэх тэгш оролцоог иргэд хоорондын болон улс орон, бүс нутаг, глобал түвшинд судалж үзжээ.

1993 он- Засаглал дахь иргэдийн оролцооны талаар тусгайлан авч үзсэн. Засаглал дахь иргэдийн оролцоог сайжруулахын тулд хэрэгжүүлэх хоёр төрлийн стратегийг бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдад зөвлөмж болгосон юм.

1994 он- Хүний аюулгүй байдлын шинэ тодохойлолын дагуу хийгдсэн судалгаа шинжилгээг нэгтгэн дүгнэсэн юм. Хүний аюулгүй байдалд нөлөөлж буй хүчин зүйл тус бүрийн хандлага, цаашид улс орнууд бодлогын хувьд ямар ирга хэмжээ, стратеги баримтлах талаарх ерөнхий зөвлөмжүүдийг тусгасан байна.

1995 он- Хүний эрх, тэгш бус байдал, ялангуяа жендэрийн тэгш бус байдлын талаар гүнзгийрүүлэн авч үзжээ. Түүнчлэн жендэрийн тэгш бус байдлыг тодорхойлогч жендэрийн хөгжлийн индекс, мөн эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдийн шийдвэр гаргах процесст оролцох оролцоог харуулсан жендэрийн статусын индексийг тус тус тооцоолж эхэлсэн юм.

1996 он- Эдийн засгийн өсөлт болон хүний хөгжлийн хоорондын хамаарлыг гол судлагдахуун болгож, өсөлт болон хөгжлийн хоорондын хамаарал сул байгаа шалтгааныг өсөлтийн таван шинжээр тодорхойлсон.

1997 он- Ядуурлыг бууруулахад туслах эдийн засгийн бодлогууд болон эдийн засгийн зохицуулалтын талаар авч үзэн, хамгийн гол нь бид юу хийх ёстой болон хийх ёсгүйг тодорхойлох, улс төрийн бодлого ихээхэн ич холбогдолтой гэдгийг дурдсан.

1998 он- Өнөөдрийн оршин байгаа тэгш бус -хэрэглээний хандлага, хэлбэрүүд болон түүний үр дагаврын талаар авч үзсэн. Ялангуяа зүй зохисгүй хэрэглээ нь байгаль орчны хор хохирлыг уриалан дуудагч болж байгаа бөгөөд ядуу буурай орнуудын хүн амд илүү их дарамтыг бий болгож байгааг харуулжээ.

1999 он- Хүний хөгжлийн асуудлуудыг даяаршилтай холбож судалсан. Даяаршилын үйл явц нь орлого, ажил эрхлэлт, боловсрол болон бусад хүчин зүйлст хэрхэн нөлөө үзүүлж байгааг нарийвчлан судалжээ.

2000 он- Өргөн хүрээтэйгээр хүний эрх болон хүний хөгжлийн хоорондын холбоо хамаарлыг дахин судлан тодорхойлжээ. Улс төрийн болон иргэний эрх чөлөөг дэмжсэн бодлогуудыг түлхүү боловсруулж гаргахыг эрх баригчдад зөвлөмж болгосон.

2001 он- Технологийг хүний хөгжлийн асуудлуудтай холбож судалжээ. Технологи нь хүний хөгжлийг сайжруулж урамшуулахад хэрэглэгдэх хэрэгсэл болохоос орлогыг өсгөх хэрэгсэл бус гэдэг талаас нь гаргасан.

2002 он- Хүний хөгжилд нөлөөлөх ардчилсан засаглалын шинж чанарыг засаглалын бүхий л түвшинд, тэрчлэн дэлхийн засаглалын түвшинд тодорхойлж, ядуурал, хүний хөгжилд ямар дам болон шууд нөлөөлөл үзүүлж болохыг баримт судалгаагаар харуулсан.

2003 он- Мянганы хөгжлийн зорилтыг хэрхэн хангах талаарх зөвлөмжийг өөртөө агуулжээ.

2004 он- Соёлын ялгаатай байдал болон соёлын эрхийн асуудлуудыг хөндөж гаргасан. Дээрх асуудлуудыг шийдэх хамгийн оновчтой бодлогын талаарх хувилбаруудыг дэвшилгүй тавьснаараа нилээд шинэлэг болжээ.

2005 он- Улс орнуудын хоорондын олон улсын харилцаа, худалдаа, хөгжиж буй болон хөгжингүй орнуудын хоорондын зөрчилтэй асуудлуудыг хөндөж тавьжээ.

2006 он- Дэлхий нийтэд тулгараад байгаа хамгийн эмзэг асуудал болох үндэс усны хомсдолыг дэлхий нийтэд таниуулж байна.

Дэлхийн хүний хөгжлийн илтгэл нь 1990 оноос эхлэн НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд анх хэвлэгдэн гарчээ. Хүний хөгжлийн үзэл баримтлалыг анхлан боловсруулагч Пакистаны нэрт эдийн засагч

Махбуб Улл Хакийн санаачилга, хүчин зүтгэлээр эхний цуврал таван хэвлэгдсэн юм. Чухам энэ үеэс хүний хөгжлийн үзэл баримтлал дэлхий даяар тархах үндэс суурь тавигджээ. Мөн энэхүү үзэл баримтлалыг

хөгжүүлэхэд Энэтхэгийн нэрт эдийн засагч, нобелийн шагналт Амартя Сен чухал хувь нэмэр оруулсан юм.

1990 онд хэвлэгдсэн дэлхийн хүний хөгжлийн анхны илтгэлээр эдийн засгийн өсөлт болон хүний хөгжил хоёрын хоорондын харилцан хамаарлыг анх судлан гаргажээ. Энэ илтгэлд хөгжлийн эцсийн зорилт нь хүмүүсийн сонголтыг өргөжүүлэх замаар хүний хөгжлийг хангахад чиглэгдэнэ, орлого нь эдгээр сонголтуудыг хэрэгжүүлэх зөвхөн нэг чухал хэрэгсэл болохыг онцлон тэмдэглэжээ. Эрүүл мэнд, боловсрол, бодит орчин болон эрх чөлөө нь орлоготой адил чухал боломж сонголтуудыг өөртөө агуулдаг болохыг харуулсан. Эдийн засгийн өсөлтийн өндөр түвшин болон орлого нь хүний хөгжлийн түвшинтэй ямагт эерэг хамааралтай болох хуучин ойлголтоос татгалзахад хүргэсэн юм. Харин эдийн засгийн өсөлт хаанаас бий болж байгаа эсэх, өсөлт болон орлого нь иргэд хүмүүст хэр тэгш шударга хуваарилагдаж байгаа эсэх, ажлын байрын боломжийг хэр нэмэгдүүлж байгаа эсэхээр чанартай болон чанаргүй өсөлт гэсэн ойлголтуудыг бий болгож, улс орнуудын хөгжлийн бодлого стратегитэй холбож өгсөн нь бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчдын анхаарлыг зүй ёсоор татжээ. Энэхүү илтгэлд хөгжиж буй орнуудын хөгжлийн стратеги төлөвлөгөө нь дээрх чанаргүй өсөлтөөс зайлсхийж чанартай өсөлтийг бий болгоход чиглэгдэх ёстойг зөвлөмж болгосон байдаг.

Хүний хөгжлийн илтгэл 1991-д хүний хөгжлийн асуудлуудыг санхүүжүүлэх механизмыг дэлгэрэнгүй авч үзжээ. Энэхүү илтгэлийн гол дүгнэлт нь төсвийн зарлагын бүтцийг өөрчилснөөр анхдагч нийгмийн үйлчилгээг санхүүжүүлэх хангалттай нөөц бололцоо байгааг гаргаж тавьсанд оршино. Үнэн хэрэгтээ санхүүгийн нөөц боломж, хөрөнгө дутагдахаасаа илүү дээд түвшний шийдвэр гаргагчдын улс төрийн зориг эрмэлзэл, сэтгэлгээний дутагдлаас үүдэн оновчтой бус төсвийн зарцуулалт их байгааг уг илтгэлээр шүүмжлэн харуулсан. Хөрөнгийн нүрашиггүй зарцуулалт, алдагдсан боломжийг жишээгээр дурдахад, цэрэг армийн зардлын өсөлт, улсын үйлдвэрийн

газрын үр ашиггүй санхүүжилт, хэрэгцээ шаардлагагүй олон төрлийн төслийн санхүүжилт, авилгал хээл хахуульд өгч буй зардлуудыг дурдсан байна. Уг илтгэлд хөгжиж буй орнуудын засгийн газрын зарлагын бүтцийн өөрчлөлтийн хувьд тавин тэрбум долларыг үр ашигтай, хүний хөгжлийг дэмжсэн хөрөнгө оруулалтанд зарцуулах боломж байсныг дурджээ.

Дэлхийн хүний хөгжлийн 3 дахь удаагийн (1992 он) илтгэл нь зах зээлийн боломжийг хүртэх тэгш оролцоог иргэд хоорондын болон улс орон, бүс нутаг, глобал түвшинд судалж үзжээ. Илтгэлд тэмдэглэснээр, сүүлийн гучин жилд баян болон ядуу иргэдийн хоорондох эдийн засгийн ялгаатай байдал 2 дахин өссөн байна. Дэлхийн хүн амын хорин хувийг эзлэх хамгийн ядуу хэсэгт дэлхийн нийт бүтээгдхүүний 1.3 хувьтай тэнцэхүйц орлого ногдож, нийт худалдааны зөвхөн 1 хувьд хамрагдаж, нийт хөрөнгө оруулалтын 1.3 хувь л тэдэнд зориулагджээ. Мөн улс төрийн эрх чөлөө нь хүний хөгжлийн нэг чухал бүрэлдэхүүн хэсэг болохыг энэ илтгэлээр тод томруун гаргаж ирсэн. Энэхүү илтгэлээс улбаалан шинээр улс төрийн эрх чөлөөний индексийг жил бүрийн хүний хөгжлийн үзүүлэлтэнд нэмэж тооцохоор болжээ. Улс төрийн эрх чөлөөний индекс нь хувь хүний аюулгүй байдал, хууль дүрэм, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх байдал, улс төр дэх иргэдийн оролцоо, аливаа зүйл хийх боломжийн тэгш байдал гэсэн үндсэн таван бүрэлдэхүүн үзүүлэлтээр тооцоологджээ.

Хүний хөгжлийн илтгэл 1993 нь засаглал дахь иргэдийн оролцооны талаар тусгайлан авч үзсэн. Энэхүү илтгэлээс засаглал дахь иргэдийн оролцоог сайжруулахын тулд дараах хоёр төрлийн стратегийг баримталж хэрэгжүүлэхийг бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдад зөвлөмж болгосон юм. Нэгдүгээрт иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааг идэвхжүүлж сайжруулах, хоёрдугаарт хот болон нийслэлд төвлөрсөн засаглал болон эдийн засгийн эрх мэдлийг орон нутагт шилжүүлэх асуудал юм.

Хүрээлэн буй байгаль орчны асуудал, эмэгтэйчүүдийн жендэрийн асуудал, хүний

эрхийн асуудлаар бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдад нөлөөлөхүйц үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын оролцоо чухал байр суурь эзлэхийг онцлон тусгажээ. Хөгжиж буй орнуудын орон нутаг дахь төсвийн зарцуулалт нийт төсвийн 10 хүрэхгүй хувийг эзэлж байгаа бол энэ үзүүлэлт хөгжилтэй орнуудын хувьд 25 хувь байжээ. Иймд хөгжиж буй орнуудын хувьд хот хөдөөгийн ялгаатай байдал, шилжих хөдөлгөөн, орон нутгийн хөгжлийг дэмжихийн тулд засаглал дахь орон нутгийн эрх мэдлийг оновчтой хуваарилах нь үндсэн суурь арга хэмжээ болохыг зөвлөмж болгосон байна.

Коммунист дэглэм задран унаж, үзэл суртлын дайсагналцал төгсгөл болсноор хүний аюулгүй байдал, аюулгүй аж төрөх ойлголтонд эргэлт гарч, улмаар түүнийг огт өөр өнцгөөс тодорхойлж эхэлсэн. *Дэлхийн хүний хөгжлийн илтгэл 1994*-д хүний аюулгүй байдлын шинэ тодохойлолтын дагуухийгдсэн судалгаа шинжилгээг нэгтгэн дүгнэсэн юм. Хүний аюулгүй байдал нь хувь хүн, улс орон, бүс нутгийн хэмжээнээс хальж, глобал түвшний асуудал болон хувирч байна. Хүйтэн дайны үед тухайн улс орны аюулгүй байдал хангагдсанаар хувь хүний аюулгүй байдал хангагдана гэсэн үзэл баримтлал зонхилж байсан бол 21-р зуунд энэ ойлголт бүрмөсөн шинэчлэгдэж байна. Үүний тод томруун жишээ бол аливаа хувь хүн, улс орныг ялгаварлахгүйгээр тархах мансуурах бодисын наймаа, халдварт өвчнүүд, байгаль орчны бохирдол, террорист үйл ажиллагаанаас болж хүний аюулгүй байдал эрсдэлд орж байгаа явдал юм. Энэ илтгэлээр хүний аюулгүй байдалд нөлөөлж буй эдгээр хүчин зүйл тус бүрийн хандлага, цаашид улс орнууд бодлогын хувьд ямар арга хэмжээ, стратеги баримтлах талаарх ерөнхий зөвлөмжүүдийг тусгасан байна. Тухайлбал суурь боловсрол, эрүүл мэнд, ундны усны хангамж болон бусад үйлчилгээнүүдэд зориулж хөгжиж буй орнуудын хувьд 20:20 гэсэн стратегийг баримталж болох талаар санал дэвшүүлжээ. Энэ нь тухайн улс орон жилийн дотоод төсвийнхөө хорин хувийг, гадны донор орнууд болон байгууллагуудын тусламжийн мөн хорин хувийг хүний анхдагч хэрэгцээг

хангах үйлчилгээнд зарцуулж байх хэрэгтэй гэсэн үзэл баримтлал юм.

Жендэрийн тэгш бус байдлын асуудал нь жил жилийн дэлхийн хүний хөгжлийн илтгэлд тодорхой байр суурь эзэлсээр ирсэн. *Дэлхийн хүний хөгжлийн илтгэл 1995*-д хүний эрх, тэгш бус байдал, ялангуяа жендэрийн тэгш бус байдлын талаар гүнзгийрүүлэн авч үзжээ. Энэхүү илтгэлд дурдсанаар: «...жендэрийн тэгш байдалд хүрнэ гэдэг нь технократ зорилт биш юм..., энэ нь сэтгэлгээнд эрс өөрчлөлтийг хийхийг шаардсан улс төрийн процесс» гэж тодорхойлжээ. 1995 оны илтгэлээс эхлэн анх удаа жендэрийн тэгш бус байдлыг тодорхойлогч жендэрийн хөгжлийн индекс, мөн эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдийн шийдвэр гаргах процесст оролцох оролцоог харуулсан жендэрийн статусын индексийг тус тус тооцоолж эхэлсэн юм. Мөн дэлхийн улс орнуудын хувьд эмэгтэйчүүдийн чадавхи, улс төрийн оролцоо өргөжиж байгаа хэдий ч энэ нь улс орон бүрд харилцан адилгүй, тэр бүр эрчүүдтэй адил бололцоонд хүрч очиж чадаагүй байгааг цохон тэмдэглэсэн. Энэхүү илтгэлд дурдсанаар эдийн засгийн үйл ажиллагааны нилээд хувийг эмэгтэйчүүд бий болгож байгаа хэдий ч тэдний хөдөлмөрийг үнэлэх үнэлэмж доогуур, зарим тохиолдолд огт үнэлэгдэхгүй байна гэж дүгнэжээ. Эмэгтэйчүүдийн ажил хөдөлмөрийн ийм доогуур үнэлгээ нь зөвхөн тооцоолол бүртгэлийн болон шударга байдлын өнцгөөс харахаас илүүтэйгээр үндсэн шалтгаан нь эмэгтэйчүүдийн нийгэм дэх статус, байр суурьтай холбоотой. Эмэгтэйчүүдийн нийгэм дэх статусыг дээшлүүлэх, нийгэм эдийн харилцаа, үйл ажиллагаанд илүү татан оролцуулах, тэдгээрийн ажил хөдөлмөрийн үнэлэмжийг өсгөх асуудал бүхэлдээ нэгэн цогц асуудал болон тавигдаж байгааг уг илтгэлээр харуулахыг зорьжээ.

Хүний хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд эдийн засгийн өсөлт нь хүмүүсийн хувьд өөрсдийн боломж, сонголтуудаа хэрэгжүүлэх гол арга хэрэгслийн нэг хэмээн үздэг. Хэдий тийм ч өнөөгийн хөгжлийн үйл явц нь өөртөө дараах хоёр шинжийг агуулж байна. Нэгдүгээрт сүүлийн 15 жилийн

хугацаанд дэлхийн хүн амын гуравны нэг нь амьдардаг 100 гаруй улс орны хувьд эдийн засгийн өсөлт нь дээрх боломж, сонголтоо хэрэгжүүлэх арга хэрэгсэл болж чадаагүй байна. Хоёрдугаарт эдийн засгийн өсөлт болон хүний хөгжлийн хоорондын холбоо хамаарал нь ихэнх орнуудын хувьд сул бөгөөд харилцан адилгүй байв. Зарим улс орнуудын хувьд эдийн засгийн өсөлт нь их байхад хүний хөгжил нь бага, харин зарим орнуудын хувьд эдийн засгийн өсөлт нь бага хэдий ч хүний хөгжлийн үзүүлэлт нь сайн байх тохиолдлууд байсан. Чухамдаа эдийн засгийн өсөлт болон хүний хөгжлийн хоорондын хамаарлыг **1996 оны дэлхийн хүний хөгжил**-д гол судлагдахуун болгожээ. Уг илтгэлд өсөлт болон хөгжлийн хоорондын хамаарал сул байгаа шалтгааныг дараах таван өсөлтийн шинжээр тайлбарлаж болно хэмээн тодорхойлсон.

- Ажлын байргүй өсөлт: Нийт эдийн засаг өссөн хэдий ч ажил эрхлэлтийн боломж нэмэгдээгүй,

- Хуваарилалтгүй өсөлт: Эдийн засгийн өсөлтийн үр шимийг хэдхэн тооны баячууд хүртэж байхад хэдэн зуун мянган хүмүүс ядуу хэвээрээ байх,

- Дуугүй өсөлт: Эдийн засгийн өсөлт нь ардчилал, зах зээлийн боломжийн хумигдмал байдалд үүссэн өсөлт,

- Үндэс суурьгүй өсөлт: Хүмүүсийн соёлын үнэт зүйлсийг сулруулах шалгаант өсөлт,

- Ирээдүйгүй өсөлт: Өнөөгийн үе нь ирээдүй хойч үеийнхээ хэрэгцээт нөөцийг шавхах замаар бий болох өсөлт

Дээрх өсөлтийн таван шинж нь дангаараа юмуу хавсарсан байдлаар үүссэн тохиолдолд эдийн засгийн өсөлт болон хүний хөгжлийн хоорондын холбоос сул байдлаар ажиглагдана гэж үзжээ.

Дэлхийн хүний хөгжлийн илтгэл 1997 нь урт удаан хугацаанд оршин байгаа ядуурлыг арилгахын тулд юуг бид хийх ёстой вэ? Гэсэн чухал асуудлыг хүн төрөлхтний өмнө тавьсан юм. 1997 оны хүний хөгжлийн илтгэлд ядуурлыг бууруулахад туслах эдийн засгийн бодлогууд болон эдийн засгийн

зохицуулалтын талаарх хэлэлцүүлгээс гадна хамгийн гол нь бид юу хийх ёстой болон хийх ёсгүйг тодорхойлох улстөрийн бодлого ихээхэн ач холбогдолтой гэдгийг дурдсан. Улс орнуудад дутагдаж буй хамгийн чухал зүйл нь санхүүгийн нөөцийн болон эдийн засгийн шийдлүүдээс илүүтэйгээр улс төрийн оролцоо маш чухал үүрэгтэй юм. Улс төрийн шинэчлэлт нь эдийн засгийн шинэчлэлтэй хамт цаг үргэлжид хийгдэж чадвал улс орнууд «ядуурлыг бууруулах» амжилт гаргаж чадахыг зөвлөмж болгосон.

Хүний хөгжлийн илтгэлүүд нь дэлхий дахины улс орнууд болон хувь хүмүүсийн аж байдлын хоорондын харилцан хамаарал болон үр дагаврын өсөлтийг тодорхой хэмжээгээр хөнджээ. Ялангуяа харилцан хамаарал нь дэлхийн хүн амын хэрэглээний төлөв байдал, түүний байгаль орчинд нөлөөлөх нөлөөллөөр тодорхойлогдож байна. **1998 оны дэлхийн хүний хөгжлийн илтгэл** нь өнөөдрийн оршин байгаа тэгш бус хэрэглээний хандлага, хэлбэрүүд болон түүний үр дагаврын талаар илүү нарийн гүнзгийрүүлж судлан авч үзсэн. Ялангуяа зүй зохисгүй хэрэглээ нь байгаль орчны хор хохирлыг уриалан дуудагч болж байгаа бөгөөд ядуу буурай орнуудын хүн амд илүү их дарамтыг бий болгож байгааг харуулжээ. Уг илтгэлд дурдсанаар зарим улс орнуудын хүн амын хувьд хэт их хэрэглээтэй, зарим орнуудын хүн амын хувьд анхдагч хэрэгцээгээ ч хангаж чадахгүй байгааг тусган харуулж, улмаар байгаль орчны бохирдол, доройтол нь дээрх хоёр хэрэглээний аль алинаас үүсэн бий болж байгааг баримт жишээгээр тайлбарласан.

Хүний хөгжлийн илтгэл 1999 нь хүний хөгжлийн асуудлуудыг даяаршилтай холбож судалсан. Даяаршлын үйл явц нь орлого, ажил эрхлэлт, боловсрол болон бусад хүчин зүйлст хэрхэн нөлөө үзүүлж байгааг нарийвчлан судалжээ. Эдгээр судалгаагаар даяаршлын эерэг болон сөрөг талуудыг тодорхойлж, улс орны хөгжлийн бодлогод ямар нөлөө үзүүлж буйг гаргаж ирсэн. Даяаршлын үзүүлэх нөлөөллийн талаарх олон талын судалгаанууд байдаг боловч эдгээр судалгаа нь хүнийг «үйлдвэрлэлийн хүчин зүйл болох хөдөлмөр» гэдэг талаас

илүү тусгаж, чухам хүн гэдэг утгаараа хөдөлмөрт тавигдах анхаарал халамжийн асуудлуудыг нилээд орхигдуулсан болохыг уг илтгэлээр тод томруун гаргажээ. Тухайлбал, улс хоорондын ажиллах хүчний шилжих хөдөлгөөн, цагаачлал, хууль бус ажил эрхлэлттэй холбоотойгоор бий болж буй сөрөг үр дагавруудыг хэрхэн бууруулах нь өнөөдөр хөгжиж буй болон хөгжингүй орнуудад тулгарч буй бэрхшээлтэй асуудлуудын нэг хэвээр байсаар байна.

Хүний эрх болон улс төрийн эрх чөлөө нь хүний хөгжлийн үзэл баримтлалын бас нэгэн тулгуур ойлголт юм. Хүний хөгжлийн илтгэлийн анхны дугааруудад хүний эрх болон улстөрийн эрх чөлөөг хүний хөгжлийн үзэл баримтлалын гол бүрэлдэхүүн хэсэг болохыг харуулсан хэдий ч улс орнуудын хувьд эдгээр асуудлууд нь төдийлөн сайжирч, шинэ шатанд гарч чадаагүй байна. *2000 оны хүний хөгжлийн илтгэл* нь илүү өргөн хүрээтэйгээр хүний эрх болон хүний хөгжлийн хоорондын холбоо хамаарлыг дахин судлан тодорхойлжээ. Уг илтгэлээр улс төрийн болон иргэний эрх чөлөөг дэмжсэн бодлогуудыг түлхүү боловсруулж гаргахыг эрх баригчдад зөвлөмж болгосон.

Дэлхийн хүний хөгжлийн илтгэл 2001-д технологийг хүний хөгжлийн асуудлуудтай холбон судалжээ. Илтгэлд тодорхойлсноор технологи нь хүний хөгжлийг сайжруулж урамшуулахад хэрэглэгдэх хэрэгсэл болохоос орлогыг өсгөх хэрэгсэл бус гэдэг талаас нь түлхүү гаргасан. Судлаачид шинэ техник технологи нь хүмүүсийн аж байдал, ажил эрхлэлт орлогыг хэрхэн өөрчилж байгаад анхаарлаа хандуулахаас илүү нийт эдийн засаг болон бүтээмжид хэрхэн нөлөөлж байгааг түлхүү анхаарч байгааг шүүмжилжээ. Энэ илтгэлд анх удаа технологийн хүртээмжийн индексийг тооцож оруулснаараа өмнөх илтгэлүүдээс ялгагдах онцлогтой болжээ. Уг индекс нь техник, технологи улс орнуудын дунд хэр сайн тархаж байгааг харуулдаг.

Ядуурлыг тогтвортой бууруулах нь эдийн засгийн зөв бодлогоос урган гарах үр дүн, улмаар эдийн засгийн орлогын шударга хуваарилалтаас гадна улс төрийн ардчилсан засаглал болон засаглалд ядуусын дуу

хоолой хэр хүчтэй нөлөөлж чадаж байгаагаас ихээхэн хамааралтай байдаг. Ядуурлын бууралт нь ядуу хүмүүс өөрсдийн улс төрийн болон эдийн засгийн боломж, сонголтоо хэрхэн нэмэгдүүлж чадах улс төрийн хүчнээс шалтгаалдаг. Хүний хөгжлийн үндсэн зорилтуудыг хангахад нийгмийн бүхий түвшин дэх засаглалын хэлбэр нь өөрөө ардчилсан засаглал байх хэрэгтэй. *Дэлхийн хүний хөгжлийн илтгэл-2002* нь хүний хөгжилд нөлөөлөх ардчилсан засаглалын шинж чанарыг засаглалын бүхий л түвшинд, тэрчилэн дэлхийн засаглалын түвшинд тодорхойлж, ядуурал, хүний хөгжилд ямар дам болон шууд нөлөөлөл үзүүлж болохыг баримт судалгаагаар тодотгон харуулсан.

Дэлхийн хүний хөгжлийн илтгэл 2003 нь бүхэлдээ Мянганы хөгжлийн зорилтыг хэрхэн хангах талаарх зөвлөмжийг өөртөө агуулжээ. 2000 онд 189-н орны төр засгийн дээд албан тушаалын хүмүүс оролцсон НҮБ-ын Мянганы дээд хэмжээний уулзалтаар «Мянганы тунхаглал»-ыг зарлаж, ирэх 2015 он гэхэд улс орнууд өөрийн орны ядуурлын түвшинг хоёр дахин бууруулах, ДОХ-ын халдварын тархалтыг зогсоох, бичиг үсэг үл мэдэх байдлыг арилгах гэх зэрэг найман үндсэн зорилтыг дэвшүүлсэн. Энэ илтгэлээр хөгжиж буй орнууд эдгээр зорилтдоо хүрэхийн тулд улс төр, эдийн засаг, нийгмийн хүрээнд ямар бодлого баримталж болох, мөн олон улсын байгууллагууд, донор орнуудын зүгээс нэн түрүүнд хийх шаардлагатай үйл ажиллагааны ерөнхий хүрээний талаарх зөвлөмжүүдийг боловсруулж өгчээ.

Хүн шашин шүтлэг, үндэс угсаа, үндэсний цөөнх, арьс өнгөний байдлаасаа шалтгаалан орон нутгийн болон үндэсний хэмжээнд улс төрийн аливаа үйл ажиллагаанд оролцож чадахгүй байх, улмаар ажлын байртай болох, боловсрол, эмнэлэг болон бусад нийгмийн үйлчилгээнүүдэд хамрагдаж чадахгүй байх нь дэлхийн зарим улс орнуудад түгээмэл үзэгдэл юм. «*Дэлхийн хүний хөгжлийн илтгэл 2004*» нь соёлын ялгаатай байдал болон соёлын эрхийн асуудлуудыг хөндөж гаргасан. Дээрх асуудлуудыг шийдэх хамгийн оновчтой бодлогын талаарх

хувилбаруудыг дэвшүүлэн тавьснаараа нилээд шинэлэг болжээ.

Дэлхийн хүний хөгжлийн илтгэл 2005 нь улам их даяаршиж буй өнөө үеийн улс орнуудын хоорондын олон улсын харилцаа, худалдаа, хөгжиж буй болон хөгжингүй орнуудын хоорондын зөрчилтэй асуудлуудыг хөндөж тавьжээ. Олон улсын санхүүгийн байгууллагууд болон өндөр хөгжилтэй орнуудаас буурай хөгжилтэй орнуудад үзүүлж буй зээл, тусламж нь тухайн улсын хөгжлийн бодлого, стратегитэй уялдахгүй байгаа болон эдгээр орнуудад нүүрлэж буй худалдааны хориг, саад тотгоруудыг өргөн хүрээтэйгээр шүүмжлэлт байр сууринаас судалжээ. Мөн байгалийн нөөц баялгийн хомсдол, түүний оновчтой хуваарилалтын асуудлуудыг ч тусган харуулсан.

2006 оны дэлхийн хүний хөгжлийн илтгэл нь дэлхий нийтэд тулгараад байгаа хамгийн эмзэг асуудал болох ундны усны хомсдолыг дэлхий нийтэд таниулж байна. Энэхүү илтгэлийн хүрээнд дэлхийн 1.2 тэрбум хүн ам ундны усны хомсдолд ороод байгаа болон 2.6 тэрбум хүн ундны цэвэршүүлсэн ус ууж чадахгүй байгаагийн үндсэн шалтгаан үр дагавруудыг судалсан. Үүнд ундны усны хомсдолд хүргэж буй нийгмийн болон эдийн засгийн хүчин зүйлүүдийг тодорхойлж, үндэсний болон дэлхийн хэмжээнд үүнийг хэрхэн шийдвэрлэх талаарх бодлогын зөвлөмжүүдийг тусгажээ. Түүнчлэн хил дамнан урсдаг гол, усны удирдлага зохицуулалтыг хэрхэн олон улсын түвшинд хамтран хийх тухай саналуудыг гаргасан.

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр нь 1990 онд дэлхийн хүний хөгжлийн анхны илтгэлийг гаргаснаасаа хойш улс орнуудад хүний хөгжлийн илтгэлээ үндэсний хүрээнд бэлтгэхэд нь дэмжлэг үзүүлсээр ирсэн. Хүний хөгжлийн үндэсний илтгэл нь тухайн улсын хөгжлийг хүний хөгжлийн шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэхдээ хүний хөгжлийн үндсэн үзэл баримтлалыг улс орны онцлогтой уялдуулан авч үздэг. Эдгээр илтгэлүүд хүмүүсийн ойлголт, хүсэл эрмэлзлийг нарийн томъёолж, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн боломж, чадамжид гарч байгаа дэвшил, ухралтыг тодруулах, хүн

төвтэй бодлогыг түгээх, хөгжлийг төлөвлөх хэрэгсэл, арга зүйн зөвлөмж болгоход чиглэгддэг. Монголын хүний хөгжлийн анхны илтгэл (1997) нь шилжилтийн үеийн Монголын ард түмний аж байдлын түвшинд үнэлгээ өгсөн билээ. Монголын хүний хөгжлийн хоёр дахь илтгэл (2000) өнөөгийн Монгол улсад төрийн гүйцэтгэх үүрэгт анхаарал хандуулж, улмаар задлан шинжилгээ хийх, иргэд төрөөс ямар зүйл хүсэн хүлээж байгаа талаар өргөн шүүмжлэл, мэтгэлцээн өрнүүлэх оролдлого хийсэн юм. Монголын хүний хөгжлийн гурав дахь илтгэл (2003)-д хот, хөдөөгийн ялгаатай байдлыг авч үзжээ. Уг илтгэлд эдийн засгийн салбарт зарим нааштай өөрчлөлт гарч байгаа хэдий ч хот, хөдөөгийн хооронд ихээхэн ялгаа бий болж байгааг онцлон тэмдэглэжээ. Орлогын ядуурал хот суурин газарт хөдөөтэй харьцуулахад илүү түгээмэл байгаа болон тэгш бус байдал нь дотоод шилжих хөдөлгөөн, хотжих үйл явцад түлхэц өгч, хотын ядуурал нэмэгдэх зэрэг бусад бэрхшээлийг бий болгож байгаа талаар тусгажээ. Шилжих хөдөлгөөний судалгаанаас харахад 2015 он гэхэд Улаанбаатар хотод нийт хүн амын тэн хагас нь суурших төлөвтэй байна. **Монголын хүний хөгжлийн илтгэл (2003)** нь хот, хөдөөгийн хүний хөгжлийн ялгааг задлан шинжилж, эдгээр өөрчлөлтөд төр засаг, иргэдээс үзүүлж буй хариу үйлдлийн талаар өгүүлэн, хот, хөдөөгийн ялгааг арилгахад чиглэсэн бодлогын хувилбаруудыг санал болгосон.

Монголдахь НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрөөс **«Монголын хүний хөгжлийн илтгэл 2006»** бичих ажлыг санаачлан хэрэгжилтийн шатанд явж байна. Энэ удаагийн хүний хөгжлийн илтгэл нь «Ажил эрхлэлт ба ядуурал» гэсэн сэдвийн дор бичигдэж байгаа бөгөөд гол зорилго нь ядуурлыг бууруулах стратеги боловсруулахад нэн ач холбогдол бүхий монголын эдийн засгийн үндсэн шинж чанаруудыг тодорхойлж, улмаар бодлогын зохих шийдлүүдийг санал болгоход оршиж байна.

Ашигласан материал

1. Readings in Human Development, Oxford university press, 2003
2. World human development reports (2000-2006)
3. Монголын хүний хөгжлийн илтгэлүүд (1997, 2000, 2003)